БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Я.АМАРЖАРГАЛ

НИЙЛҮҮЛЭГЧ

МОНФА ТРЕЙД ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

А.ДАРЬБАЛ

# ШИНЭ КОРОНАВИРУСТ ХАЛДВАР(COVID-2019)-ЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № 81

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас Монфа трейд ХХК(цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь эм, Шинэ коронавирусТ халдвар (Багц-19)-ын үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахгэрээг (цаашид “бараа” гэх) 39,600,000 (гучин есөн сая зургаан зуун мянган) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хүснэгт 1. Нийлүүлэх бараа

| Д/Д | Барааны нэр, төрөл | Багцийн дугаар | Үйлдвэрлэгчийн нэр, Үйлдвэрлэсэн улс | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгж үнэ /НӨАТ орсон/ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Добутамин | 19 | PT. Bernofarm for PT.Pertiwi Agung, Индонези | Тун шил | 2000 | 19800 | 39,600,000 |
| | Дүн | 39,600,000 төгрөг | | | | | |

1. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 39,600,000(гучин есөн сая зургаан зуун) төгрөгийг Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

2. Нийлүүлэгч нь 1 нэр төрлийн барааны нийлүүлэх хэмжээний 50 хувийг буюу 1000 тун шилийг гэрээ байгуулмагц 2020 оны 3 сарын 18-ны өдөр хүлээлгэж өгнө. Үлдсэн 1000 тун шилийг 2020 оны 4 сарын 20-ны өдөр нийлүүлнэ.

3. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

   Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
   Бусад шаардлагатай баримт бичиг[1];
   Тендер ба үнийн хуваарь;
   Гэрээний тусгай нөхцөл;
   Гэрээний ерөнхий нөхцөл;
   Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
   Санхүүжилтийн хуваарь.

   Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

4. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

5. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

6. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хүснэгт 1. Санхүүжилтийн хуваарь

| Д/Д | Барааны нэр, төрөл | Багцийн дугаар | Урьдчилгаа /төгрөг/ | Гүйцэтгэл /төгрөг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Добутамин | 19 | 19,800,000 | 19,800,000 |
| 2 | | | | |
| | **Нийт дүн** | | 19,800,000 | 19,800,000 |

[1] Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

| | |
|---|---|
| ГЕН 29.1 | Эрүүл мэндийн яам, Засгийн газрын 8 дугаар байр, Улаанбаатар-48, Олимпийн гудамж-2 |
| **30. Татвар, хураамж (ГЕН-ийн Зүйл 30)** | |
| ГЕН 30 | Монгол Улсын нутаг дэвсгэрийн гаднаас болон дотоодоос нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодисыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн ХӨСҮТ-д болон эцсийн цэгт захиалагчид хүргэх хүртэл оногдуулсан бүх татвар хураамж, тээвэр, даатгал болон бусад зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна. |

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга
.........................................Г.Цэцэнсанаа

Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
.........................................Т.Бямбасүрэн

Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн
.........................................Т.Мөнхтуул

Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
.........................................Г.Бат-Эрдэнэ

Эрүүл мэндийн яамны нягтлан Бодогч
.........................................Э.Эрдэнэцэцэг

Эрүүл мэндийн яамны хуулийн хэлтсийн Мэргэжилтэн
.........................................Д.Мөнхцэцэг

*14210 Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр*

*Утас:*263695

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Монфа трейд ХХК-ийн
Тендер хариуцсан менежер
.........................................Х.Сэргэлэн

Хаяг: Жуулчны гудамж, 3-р хороо
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар
Утас: 324420, 99046060

Регистрийн дугаар:2733617
Банк: Хас банк
Дансны дугаар: 5001192580